

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
МЭДЭЭЛЭЛ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХУРАЛДААНЫ ИРЦИЙГ ХЭРХЭН
ТООЦОЖ БҮРДҮҮЛДЭГ, ХУРУУНЫ ХЭЭГЭЭР ИРЦ БҮРТГЭДЭГ ЭСЭХ
ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН МЭДЭЭЛЭЛ

(Мэдээлэл лавлагаа)

СТ-17/408

Хянасан: Ц.Норовдондог /Ph.D/

Гүйцэтгэсэн судлаач: Г.Алтан-Оч
Г.Билгээ
Ө.Мөнхтунгалаг
Д.Халиун

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	2
НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХУРЛЫН ИРЦИЙГ ТООЦОЖ БҮРДҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	4
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХУРАЛДААНЫ САНАЛ ХУРААЛТАД ХУРУУНЫ ХЭЭ АШИГЛАХ ТУХАЙ	8
<i>Албани.</i>	9
<i>Болгар.</i>	9
<i>Итали.</i>	10
<i>Шри Ланк.</i>	10
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	13

УДИРТГАЛ

УИХ-ын гишүүн Л.Оюун-Эрдэнийн захиалгаар “Хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны ирцийг хэрхэн тооцож бүрдүүлдэг, хурууны хээгээр ирц бүртгэдэг эсэх талаарх харьцуулсан мэдээлэл” сэдэвт лавлагааг гүйцэтгэв.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд гишүүний захиалгад дурдсан БНХАУ, БНСУ, Япон, ХБНГУ, АНУ, ОХУ зэрэг 6 улсад хууль тогтоох дээд байгууллагын хурлын ирцийг хэрхэн тооцож, бүртгэдэг, мөн хурууны хээгээр ирц бүртгэдэг эсэх талаар Үндсэн хууль, дэг болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судаллаа. Судалгаанд хамрагдсан парламентын хоёр танхимтай орнуудын хувьд шууд сонгуулиар сонгогддог доод танхимууд, БНХАУ-ын хувьд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал /БХАТИХ/ болон БХАТИХ-ын Байнгын хороо /Бага Хурал/-ны холбогдох зохицуулалтыг тус тус судалсан болно.

Судалгааны хураангуй: Судалгааны ажил нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд *нэгдүгээр хэсэгт*, хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны ирцийг¹ тооцож бүрдүүлэхтэй холбоотой Үндсэн хууль, дэг болон холбогдох хуулийн зохицуулалт, *хоёрдугаар хэсэгт*, хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны ирцийг бүртгэхэд, санал хураалтад биометрийн мэдээлэл буюу хурууны хээ ашигладаг эсэх талаар судаллаа.

Судалгаанд хамрагдсан 6 улсын 4-т нь гишүүдийн олонх буюу 50%+1 хүрэлцэн ирснээр хууль тогтоох дээд байгууллагын хуралдааныг хүчинтэйд тооцдог бол Японд гишүүдийн 1/3 буюу 33,3%+1, БНХАУ-ын БХАТИХ-ын гишүүдийн 2/3 буюу 66,6%+1 дээш хүрэлцэн ирснээр хуралдааныг тус тус хүчинтэйд тооцдог байна.

Улсын нэр	Танхимын тоо	Танхимын нэр	Гишүүдийн тоо ²	Хуралдааны ирц
АНУ	2	Senate	100	
		House of Representatives	430	50%+1
БНСУ	1	National Assembly	300	50%+1
		National People's Congress	3000	66,6%+1
БНХАУ	1 ³	Standing Committee	300	50%+1
		Совет Федерации	170	
ОХУ	2	Государственная Дума	450	50%+1
		Bundesrat	69	
ХБНГУ	2	Bundestag	630	50%+1
		House of Councillors	242	
Япон	2	House of Representatives	475	33,3%+1

¹ Шийдвэр гаргах чадамж (латинаар: *quorum-кворум*) гэж хамтын шийдвэр гаргадаг байгууллагын хувьд саналын эрх бүхий хуралдаанд оролцож буй гишүүдийн ирц нь байвал зохих хамгийн бага тоонд хүрсэн буюу түүнийг давсан байхыг эрхзүйн хэм хэмжээгээр тогтоосныг хэлнэ. Хамтын шийдвэр гаргадаг байгууллагад удирдах дээд байгууллага, парламент, холбоо, байнгын хороо, чуулганы хуралдаан, төрийн байгууллага, нам, хувьцаа эзэмшигчдийн хурал мөн сууц өмчлөгчдийн хурал багтдаг. Ирц нь шийдвэр гаргах чадамжид хүрэх хэрэгслийг илэрхийлж буй бол санал өгөх нь олонхиор буюу бүгд санал нэгдсэн байдлаар шийдвэрт хүрэх хэрэгсэл юм.

² Хуулиар тогтоосон дээд хязгаар

³ БНХАУ-ын Үндсэн хуулийн 57-р зүйлд заасны дагуу БХАТИХ бол төрийн эрх барих дээд байгууллага мөн. Түүний байнгын байгууллага болох БХАТИХ-ын Байнгын хороо мөн. 58-р зүйлд. БХАТИХ болон БХАТИХ-ын Байнгын хороо нь хууль тогтоох эрхийг хэрэгжүүлнэ.

Парламентын гишүүдийн ирцийг бүрдүүлэх асуудлыг зарим улсын холбогдох хууль журамд нарийвчлан тогтоож өгсөн байна. Үүнд парламентын гишүүнийг хуралдаанд албадан оролцуулах, ирц болон хуралдааны явцын мэдээг нийтлэх, хуралдааныг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан гишүүнд сахилгын хариуцлага тооцох зэрэг зохицуулалтууд орж байна. Тухайлбал:

АНУ-ын Үндсэн хуулийн 1-р зүйлийн 5-р хэсэгт "...тухайн Танхимын тогтоосон журам болон шийтгэлийн арга хэмжээг хэрэглэн эзгүй байгаа гишүүдийг албадан авчирч хурлын ирцийг бүрдүүлэх эрх олгож болно. Танхимууд хуралдааныхаа явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, түүнийгээ тогтмол нийтлэх ёстой, Танхим бүр хуралдааныхаа дэгийг тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь төлөө гишүүнээ шийтгэж, мөн гуравны хоёрын саналаар гишүүнийг бүрэлдэхүүнээсээ хасаж болно." гэж заасан байна.

Японы хувьд дүрэм зөрчсөн гишүүнийг бүрэлдэхүүнээс хасах асуудлыг гуравны хоёрын саналаар шийдвэрлэх зохицуулалтыг Үндсэн хуулийн 58-р зүйлд тусгасан байна.

ОХУ-д Төрийн Думын дүрмийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэгт зааснаар танхимын хуралдаанд суугаагүй тохиолдол тус бүрт сарын хөдөлмөрийн хөлсний 1/6-г буулгах замаар хэрэжүүлнэ. Энэхүү хариуцлага хүлээлгэх тухай шийдвэрийг Төрийн Думын дүрэм сахиулах, үйл ажиллагаа зохион байгуулах хорооноос гаргаж, Төрийн Думын албан ёсны цахим сүлжээнд байршуулна.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн тухай хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу Парламентын гишүүн нь Спикерт мэдэгдэж чөлөө авсан, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй болж, үүнийгээ мэдэгдсэнээс бусад тохиолдолд Үндэсний ассамблейн гишүүний цалин хөлсний тухай хуульд заасны дагуу чуулганы хуралдааныг тасалсан өдрийн хөлсийг гишүүний тусгай үйл ажиллагааны мөнгөн тэтгэмжээс суутгахаар заасан байна.

Хуралдааны ирцийг хэрхэн тооцож бүрдүүлэхтэй холбоотой Үндсэн хууль болон холбогдох бусад хуулийн зохицуулалтыг Хүснэгт 1-ээс үзнэ үү.

Хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны ирцийг хурууны хээгээр бүрдүүлдэг эсэх асуудлын хувьд, захиалагчаас ирүүлсэн хүсэлтэд дурдсан орнууд энэ аргыг нэвтрүүлсэн эсэх талаар холбогдох хууль, журмын зохицуулалт олдсонгүй. Харин Кени⁴, Уганда, Зимбабве⁵, Өмнөд Африк зэрэг орнуудад гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэх аргыг хэрэглэдэг байна.

Хууль тогтоох дээд байгууллагын хуралдааны санал хураах аргын хувьд, Албани, Болгар, Итали, Шри Ланк зэрэг орнуудад парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээ ашиглах тогтолцоог нэвтрүүлсэн байна. Дэлгэрэнгүй мэдээллийг хоёрдугаар хэсгээс үзнэ үү.

⁴ <http://www.bbc.com/news/world-africa-26137631>

⁵ <https://openparly.co.zw/2017/03/17/parly-installs-biometric-access-system-to-generate-mps-electronic-attendance-register/>

НЭГ. ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХУРЛЫН ИРЦИЙГ ТООЦОЖ БҮРДҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүснэгт 1

УЛСЫН НЭР	ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ
АНУ	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>1.5. ... Танхим бүр сонгууль, түүний үр дүн болон өөрийнх нь гишүүд шаардлагад нийцсэн эсэхийг өөрөө хянана. Танхим бүрийн гишүүдийн ердийн олонхи нь ажлаа явуулах ирцийн бүрдэлтийг хангана. Гэхдээ түүнээс цөөн тооны гишүүдийн ирцтэй байвал хуралдааныг өдөр өдрөөр хойшлуулж болох бөгөөд тэдэнд тухайн Танхимын тогтоосон журам болон шийтгэлийн арга хэмжээг хэрэглэн эзгүй байгаа гишүүдийг албадан авчирч хурлын ирцийг бүрдүүлэх эрх олгож болно. Танхим бүр хуралдааныхаа дэгийг тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь төлөө гишүүнээ шийтгэж, мөн гуравны хоёрын саналаар гишүүнийг бүрэлдэхүүнээсээ хасаж болно.</p> <p>Танхим бүр хуралдааныхаа явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, түүнийгээ тогтмол нийтлэх ёстой бөгөөд түүндээ нууцын шаардлагад хамаарна гэж өөрсдийн үзсэнээс бусад зүйлийг оруулна; Аливаа асуудлаар аль ч Танхимын гишүүдийн “төлөө” болон “эсрэг” өгсөн саналыг хуралдаанд оролцогчдын тавны нэгийн хүсэлтээр сэтгүүлд нийтэлнэ.</p>
ХБНГУ	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>42.1. Бундэстагийн үйл ажиллагаа нээлттэй байна. Гишүүдийн аравны нэгийн хүсэлт буюу Холбооны Засгийн газрын хүсэлтийг үндэслэн гуравны хоёрын саналаар нээлттэй байдлыг халж болно.</p> <p>42.2. Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Бундэстагийн шийдвэр нь өгсөн саналын олонхоор гарна. Бундэстагийн дотоодын сонгуульд дотоод журмаар өөрөөр зохицуулахыг зөвшөөрнө.</p> <p><u>Германы Бундестаг (парламент)-ийн Дотоод журам:</u></p> <p>45.1. Шийдвэр гаргах чадамжтай байхын тулд Бундэстагийн гишүүдийн талаас илүү хувь нь хуралдааны танхимд ирсэн байх шаардлагатай. Хэрэв ирц бүрдсэн эсэх нь эргэлзээтэй бол тус зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Хаммэлшпрунг⁶ аргаар шалгаж болно.⁷</p> <p>45.3. Шийдвэр гаргах чадамжгүй үед Бундестаг хууль баталсан бол тэр нь хүчин төгөлдөр бус юм. Хэрэв шийдвэр гаргах чадамжгүй байдал нь тогтоогдсон бол Бундэстагийн ерөнхийлөгч хуралдааныг нэн даруй завсарлуулах үүрэгтэй.</p> <p>20.5. Дээрх байдлаар хаасан чуулганы хуралдааныг тэр өдөртөө дахин нэг удаа хуралдуулж болох бөгөөд энэ тохиолдолд Бундэстагийн аль нэг бүлэг буюу нийт гишүүдийн 5% нь эсэргүүцэл илэрхийлэх боломжтой юм.</p>

⁶ Hammelsprung-англиар *Division*, Бундестагт Хаммэлшпрунг аргыг ашиглахдаа, эхлээд бүх депутат нэгдсэн хуралдааны танхимыг орхин гарах ба Бундэстагийн ерөнхийлөгч тоолох ажиллагааг эхлүүлмэгц, тэд буцаад танхимд “Тийм”, “Үгүй” болон “Түдгэлзэх” гэсэн 3 хаалганы аль нэгээр нэвтэрч орж ирэхэд нь тоолно. Тоологчоор хаалга тус бүрт хоёр тэмдэглэл хөтөлгч ажиллах бөгөөд депутат нэвтрэх үед чангаар дуудаж тоолно. Ерөнхийлөгч тоолох ажиллагаа дууссаныг зарлана. Ийнхүү зарласны дараа орж ирсэн бол тоонд оруулахгүй. Дээрх зохицуулалтыг Бундэстагийн Дотоод журмын 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгажээ.

⁷ Бундэстагийн түүхэнд (1949-1990) Хаммэлшпрунг аргыг нийт 534 удаа ашигласан байдаг.

<p>ОХУ</p>	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>105. Холбооны хуулийн төслийг Төрийн Думын нийт гишүүдийн олонхийн саналаар батална.</p> <p><u>Гишүүн, төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хууль:</u></p> <p>12.3-т. Холбооны Зөвлөлийн гишүүн болон Төрийн Думын төлөөлөгч нь Холбооны Хурлын холбогдох танхим, хороо /комитет/, комисс /комиссия/, зөвшилцөх болон тусгай комиссын хуралдаанд биеэчлэн оролцох үүрэгтэй.</p> <p><u>Төрийн Думын дүрэм:</u></p> <p>13. Төрийн Думын хуралдааныг нийт гишүүдийн талаас дээш хувь нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.</p> <p>13. Төрийн Думын гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.</p> <p>44. Хэрэв төлөөлөгч нь хүндэтгэх шалтгаанаар холбогдох хуралдаанд оролцож боломжгүй болсон тохиолдолд энэ талаар танхим болон холбогдох хорооны даргад урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.</p> <p>44.4. Төлөөлөгчийн ийнхүү урьдчилан мэдэгдэх үүргийг мөн тусгаж, хүндэтгэх шалтгааныг дараахь байдлаар тодорхойлсон байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • түр зур хөдөлмөрийн чадвар алдсан; • гадаадад айлчлах парламентын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хамрагдан хилийн чанд руу явсан; • парламент дахь бүлгийн даргын танилцуулсныг үндэслэн Төрийн Думын даргын шийдвэрээр Төрийн Думын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хамт албан томилолтоор явсан. <p>44.5. Танхимын хуралдаанд суугаагүй тохиолдол тус бүрт сарын хөдөлмөрийн хөлсний 1/6-г буулгах замаар хэрэгжүүлнэ. Энэхүү хариуцлага хүлээлгэх тухай шийдвэрийг Төрийн Думын дүрэм сахиулах, үйл ажиллагаа зохион байгуулах хорооноос гаргаж, Төрийн Думын албан ёсны цахим сүлжээнд байршуулна.</p> <p>Төрийн Думын хуралдаан даргалагч нь хуралдааны эхэнд, завсарлагааны дараа үргэлжлүүлэн хуралдаж эхлэх бүрт танхимд орж ирсэн төлөөлөгчдийг бүртгэнэ. Төлөөлөгчид цахим карт ашиглан бүртгүүлэх, эсхүл өөрийн хүсэлтээр бүртгэлийн хуудсанд бүртгүүлж болно.⁸</p> <p>96. Төрийн Думын гишүүдийг бүртгэх, тэдний санал хураах болон бусад үйл ажиллагаанд цахим системийг ашиглана. Төрийн Думын дүрэм сахиулах, үйл ажиллагаа зохион байгуулах хороо дээр байгуулагдсан хяналтын хэсэг нь Төрийн Думын хуралдаанд цахим систем ашиглалтанд тавих хяналтыг хэрэгжүүлнэ.⁹</p>
<p>БНСУ</p>	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>49. Үндэсний Ассамблей нь Үндсэн хууль болон бусад хуульд тусгайлан заагаагүй бол нийт гишүүдийн олонхийн ирцтэйгээр хуралд оролцогч гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Санал хураалтад оролцоогүй бол татгалзсанд тооцно.</p> <p>65.1-65.2. Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, сайд, яам агентлагийн дарга, Үндсэн хуулийн шүүх, шүүх, сонгуулийн ерөнхий хороо, ерөнхий прокурор зэрэг хуульд заасан төрийн алба түүний</p>

⁸ Төрийн Думын дүрмийн 44.1, 44.2 дахь хэсэг.

⁹ Төрийн Думын дүрмийн 97 дугаар зүйл.

	<p>хэрэгжүүлэгч нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн бол УИХ хариуцлага тооцох ба огцруулна. Хариуцлага тооцох ба огцруулахад УИХ-ын гишүүдийн гуравны нэгээс дээш хувь чуулганд оролцсон байх ба гишүүдийн талаас дээш хувь зөвшөөрсөн байна. Ерөнхийлөгчийг огцруулахад гишүүдийн ирц талаас илүү байх бөгөөд оролцогч гишүүдийн гуравны хоёроос дээш хувь нь огцруулах тухай зөвшөөрсөн байна.</p> <p><u>Үндэсний Ассамблейн тухай хууль /National Assambley Act^{10/}:</u></p> <p>22. Үндэсний Ассамблейн гишүүн хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгаанаар чөлөө авах бол Үндэсний Ассамблейн даргад бичгээр хүргүүлнэ. Үндэсний Ассамблейн дарга бичгээр ирүүлсэн хүсэлтийг зөвшөөрсөн бол санал хураалтын программ оруулж ирцийг хасч тооцно.</p> <p>32.1. Парламентын гишүүн нь Парламентын чуулганы хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол тэрээр Спикерт мэдэгдэнэ, эсхүл бичгээр мэдэгдэж чөлөө авна.</p> <p>32.2. Парламентын гишүүн нь Спикерт мэдэгдэж чөлөө авсан, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар оролцох боломжгүй болж, үүнийгээ мэдэгдсэнээс бусад тохиолдолд Үндэсний ассамблейн гишүүний цалин хөлсний тухай хуульд заасны дагуу чуулганы хуралдааныг тасалсан өдрийн хөлсийг гишүүний тусгай үйл ажиллагааны мөнгөн тэтгэмжээс суутгана.</p> <p>73.1. Үндэсний Ассамблейн нэгдсэн чуулганы хуралдааныг нийт гишүүдийн 1/5 –ийн ирцтэйгээр нээж болно.</p> <p>73.2. Үндэсний Ассамблейн нэгдсэн чуулганы хуралдааныг нийт гишүүдийн ирц бүрдээгүй тохиолдолд 1 цаг хүртэл хугацаагаар хүлээнэ. Үндэсний Ассамблейн дарга ирц бүрдээгүй тохиолдолд нэгдсэн чуулганыг хойшлуулах шийдвэр гаргана.</p> <p>73.3. Мөн Үндэсний Ассамблейн нэгдсэн чуулганы хуралдааныг нийт гишүүдийн 1/5 –ийн ирц бүрдээгүй тохиолдолд парламентын гишүүд болон намын бүлгийн гишүүд нэгдсэн чуулганыг хуралдуулахаар Үндэсний Ассамблейн даргад хүсэлт гаргасан бол нэгдсэн чуулганыг хуралдуулна.</p>
<p>Япон</p>	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>56. Бүх гишүүдийн гуравны нэгээс дээш нь ирээгүй тохиолдолд аль ч тэнхим хуралдахгүй. Үндсэн хуульд өөрөөр зааснаас бусад тохиолдолд гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдэх ба санал тэнцсэн тохиолдолд даргалагч шийднэ.</p> <p>57. Танхим бүрийн үйл ажиллагаа, хэлэлцүүлэг олон нийтэд нээлттэй байна. Хуралд ирсэн гишүүдийн гуравны хоёроос доошгүй саналаар асуудлыг нууцаар хэлэлцэж болно.</p> <p>58. Танхим бүр өөрийн дарга болон бусад албан тушаалтныг сонгоно. Танхим бүр хуралдаан, дотоод журамтай холбоотой дэгээ өөрсдөө тогтоож, журам зөрчсөн үйлдлийнх нь төлөө гишүүнээ шийтгэж болно. Ингэхдээ, гишүүнийг өөрсдийн бүрэлдэхүүнээс хасах асуудлыг хүрэлцэн ирсэн гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.</p> <p><u>Улсын Хурлын тухай хууль /National Diet Law/^{11/}:</u></p> <p>124. Чуулганы нэгдсэн хуралдаан, эсхүл Байнгын хорооны</p>

¹⁰ National Assambley Act, http://korea.na.go.kr/res/low_02_read.jsp?boardid=1000000036

¹¹ <http://www.sangiin.go.jp/eng/law/diet/#ChapterXV>

	<p>хуралдааныг зарласнаас хойш гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хариу өгөөгүй, эсхүл хүрэлцэн ирээгүй, эсхүл чөлөө олгогдсон хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Даргалагч нь зарлан дуудах хуудас үйлдэж хүргүүлнэ. Зарлан дуудах хуудас хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй тохиолдолд хурал даргалагч нь уг хэргийг Сахилгын хороонд шилжүүлнэ.</p> <p>122. Сахилгын арга хэмжээ нь дараах хэлбэртэй байна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нэгдсэн чуулганы нээлттэй хуралдаан дээр сануулах, 2. Нэгдсэн чуулганы нээлттэй хуралдаан дээр уулчлал хүсэх, 3. Танхимын хуралдаанд оролцох эрхийг нь тодорхой хугацаагаар хасах, 4. Гишүүнийг бүрэлдэхүүнээс хасах. <p><u>Төлөөлөгчдийн танхимын дүрэм¹²:</u></p> <p>181. Танхимын гишүүн нь хуралдаанд тодорхой хугацаанд оролцох боломжгүй тохиолдолд Даргалагчид урьдчилан мэдэгдэж, оролцох боломжгүй шалтгаанаа заана.</p> <p>182. Даргалагч нь 7 хоногийн хугацаатай чөлөө олгож, 7 хоногоос дээш хугацаа бүхий чөлөөг Танхимаар хэлэлцэнэ. Тодорхой хугацаа заагаагүй тохиолдолд зөвшөөрөл олгох боломжгүй.</p> <p>183. Гишүүн нь чөлөө авсан хугацаандаа багтан ажилдаа орж амжихгүй тохиолдолд урьдчилсан бичгээр мэдэгдэнэ.</p> <p>184. Гишүүн нь чөлөөний хугацаагаа дуусгавар болохоос өмнө ажилдаа эргэн орсон өдөр чөлөө хугацааг дуусгавар болсонд тооцно.</p> <p>185.1. Парламентын гишүүн нь тодорхой шалтгааны улмаас чуулганд оролцох боломжгүй тохиолдолд даргалагчид Даргалагчид шалтгааныг заан, бичгээр чөлөө авна.</p> <p>185.2. Парламентын гишүүн нь хүүхэд төрүүлсний чөлөө авах тохиолдолд чөлөөний хугацааг тооцож даргалагчид урьдчилан мэдэгдэнэ.</p>
<p>БНХАУ</p>	<p><u>ҮНДСЭН ХУУЛЬ:</u></p> <p>64. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг БХАТИХ-ын Байнгын хороо, эсхүл БХАТИХ-ын гишүүдийн 1/5-ын саналаар оруулах бөгөөд, БХАТИХ-ын нийт гишүүдийн дийлэнх олонх буюу 2/3-ын саналаар шийдвэрлэнэ.</p> <p>Хууль, тогтоолын төслийг БХАТИХ-ын нийт гишүүдийн энгийн олонх буюу талаас дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.</p> <p><u>БХАТИХ-ын хуралдааны дэг:¹³</u></p> <p>4. БХАТИХ-ын гишүүдийн 2/3 ба түүнээс дээш тооны гишүүн хүрэлцэн ирсэн тохиолдолд чуулганы хуралдаан чуулна.</p> <p>16-р зүйл. БХАТИХ чуулж байгаа үед бүх гишүүд оролцох бөгөөд өвчин, эсхүл бусад шалтгааны улмаас оролцох боломжгүй бол чөлөө авна.</p> <p>52. Хуулийн төсөл болон бусад асуудлыг нэгдсэн</p>

¹² 衆議院規則, http://www.shugiin.go.jp/internet/itdb_annai.nsf/html/statics/shiryo/dl-rules.htm

¹³ Rules of Procedure for the National People's Congress of the People's Republic of China (Adopted at the Second Session of the Seventh National People's Congress and promulgated by Order No.17 of the President of the People's Republic of China on April 4, 1989)
http://www.npc.gov.cn/englishnpc/Law/2007-12/12/content_1383914.htm

хуралдааны нийт гишүүдийн энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.¹⁴

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг нийт гишүүдийн 2/3-ын саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтын дүнг хурал даргалж буй этгээд газар дээр нь мэдэгдэнэ.

БХАТИХ-ын Байнгын хорооны хуралдааны дэг:¹⁵

4. БХАТИХ-ын Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн талаас дээш хувь хүрэлцэн ирснээр хуралдуулна.

32. Хуулийн төсөл болон бусад асуудлыг Байнгын хорооны нийт гишүүдийн энгийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал хураалтын дүнг хурал даргалж буй этгээд газар дээр нь мэдэгдэнэ.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООХ ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ХУРАЛДААНЫ САНАЛ ХУРААЛТАД ХУРУУНЫ ХЭЭ АШИГЛАХ ТУХАЙ

Хурууны хээгээр ирц бүртгэх

Хууль тогтоох дээд байгууллагуудад хурууны хээгээр ирц бүртгэх асуудлыг судалгааны захиалгад дурдсан улс орнуудын холбогдох хууль журмуудад тусгаагүй байна. Харин Кени¹⁶, Уганда, Зимбабве¹⁷, Өмнөд Африк зэрэг орнуудад хууль тогтоох дээд байгууллагын гишүүдийн ирцийг хурууны хээгээр бүртгэж байна.

Хурууны хээ ашиглан хуралдааны санал хураалт явуулах

Олон улсын парламентын холбооноос гаргасан мэдээгээр дэлхийн 112 танхимын 67% нь парламентын хуралдааны санал хураалтад ямарваа нэгэн төрлийн мэдээллийн технологи /ИТ/-ийн системийг ашигладаг байна.¹⁸ Үлдсэн танхимууд нь санал хураалтыг гар өргөх байдлаар явуулдаг ба тэдгээрийн 72% нь ирээдүйд цахим тоолуур нэвтрүүлнэ гэж хариулжээ. Санал хураалтад мэдээллийн технологийн систем ашигладаг танхимууд нь санал хураалтын төрөл бүрийн хэлбэрийг ашиглаж байгаа ба хамгийн их хэрэглэгдэж буй /35%/ систем нь гишүүний карт, эсхүл жетон, мөн гишүүн бүрийн суудалд суурилуулсан товчлууур /34%/ байна.

Дээрхээс гадна хоёр дахь шатны баталгаажуулалтыг ашиглаж болох ба хамрагдсан танхимуудын 8% нь биометрийн үзүүлэлт /хурууны хээ/-ийг санал хураалтад ашиглаж байна. Мөн 8% нь санал хураалтаа гараар явуулж, тооцоолол буюу саналын хувийг тооцоолж гаргахдаа цахим тоолуур ашиглаж байна. Тухайлбал, ИБУИНВУ-ын Лордуудын танхимд гишүүд нь “тийм”, “үгүй” гэгдэх лобби коридороор алхаж, нэрээ бүртгүүлж саналаа өгдөг бол клеркүүд нь таблетын аппликейшн ашиглан саналыг тоолдог байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг Зураг 1-с үзнэ үү/.

¹⁴ Bill or proposals put to vote at the plenary meeting Simple majority of all deputies

¹⁵ Rules of Procedure for the Standing Committee of the National People's Congress of the People's Republic of China (Adopted at the 23rd Meeting of the Standing Committee of the Sixth National People's Congress on November 24, 1987, revised pursuant to the Decision of the Standing Committee of the National People's Congress on Revising the Rules of Procedure for the Standing Committee of the National People's Congress of the People's Republic of China at the 8th Meeting of the Standing Committee of the Eleventh National People's Congress on April 24, 2009) http://www.npc.gov.cn/englishnpc/Law/2007-12/12/content_1383928.htm

¹⁶ <http://www.bbc.com/news/world-africa-26137631>


¹⁷ <https://openparly.co.zw/2017/03/17/parly-installs-biometric-access-system-to-generate-mps-electronic-attendance-register/>

¹⁸ <http://www.ipu.org/pdf/publications/eparl16-en.pdf>

Санал хураалтыг мэдээллийн технологийн системийн оролцоотойгоор явуулж буй орнууд дараах шалтгаан, давуу талуудыг дурдсан байна. Үүнд:

- Санал хураалтын луйврыг бууруулах /Нэг гишүүн олон санал өгөх/;
- Санал хураалтын дүнг хурдан, шуурхай гаргах;
- Санал хураалтын дүнг нэг дор, автоматаар хүлээж авах;
- Парламентын үйл ажиллагаан дахь ил тод байдлыг нэмэгдүүлэх.

Зураг 1. Парламентын хуралдааны санал хураалтад ашиглаж буй цахим тоолуурын системийн төрлүүд /112 танхим/



Эх сурвалж: World e-Parliament Report 2016, IPU¹⁹

Хурууны хээгээр санал өгөхийг хууль, журамд тусгасан байдал

Өдгөө парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгдөг системийг Албани, Болгар, Итали, Шри Ланк зэрэг орнууд нэвтрүүлж эхлээд байна. Дээрх улс орнуудын дэг болон холбогдох бусад хууль, журмыг шүүн үзэхэд Болгараас бусад улсад холбогдох зохицуулалт тусгагдаагүй байна.²⁰

Албани. Албанийн Парламентын дэгийн 8-р бүлэгт Парламентын гишүүдийн ирц, санал хураалтын талаар тусгасан байна. 56-60-р заалтад санал хураалтад цахим тоолуурыг ашиглах талаар заасан боловч хурууны хээгээр санал өгөх зохицуулалт тусгагдаагүй байна.²¹

Болгар. Болгарын Парламент нь өөр гишүүний картаар санал өгөх асуудлыг халах зорилгоор 2010 онд хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлсэн боловч биометрийн мэдээлэл цуглуулах, гишүүний карттай уялдуулах зэрэг асуудлаас үүдэн удааширч 2013 оны 6-р сараас эхлэн бүрэн хэрэгжиж эхэлсэн байна. Болгарын Парламентын дэгийн.²²/Зураг 2/

“63.1-т: Саналыг зөвхөн өөрийн биеэр хүрэлцэн ирж өгнө. Үндэсний Ассамблейн гишүүд “тийм”, “үгүй” эсхүл “санал өгөхөөс татгалзах” гэсэн санал өгч болно. Хуульд өөрөөр заагаагүй бол Парламентаар хэлэлцэж,

¹⁹ <http://www.ipu.org/pdf/publications/eparl16-en.pdf>

²⁰ ХБНГУ-ын Бундестаг дээр ерөнхийдөө гар өргөх буюу “босох, эсхүл сууж үлдэх” маягаар санал хураадаг. Хуралдааныг даргалагч нь эсрэг санал хураасны дараа ч санал хураалтын дүнд санал нэгтэй бус байвал Хаммэлшпрунг аргыг хэрэглэнэ. Бундестагт бусад тооллогын аргыг ашигладаггүй. ОХУ, Итали, Франц, Швейцар зэрэг улсуудад хэрэглэдэг цахим тооллогын аргыг Германы Бундестагт богино хугацаагаар туршиж үзээд, булхай гаргах боломжтой гэдэг шалтгаанаар татгалзсан байдаг.

²¹ http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf

²² <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>

батлах бүхий л хууль, тогтоомжийн санал хураалтыг илээр явуулна. Үндэсний Ассамблейн бүрэн эрхийн хүрээнд тодорхой хууль, тогтоомжийн санал хураалтыг нууцаар явуулж болно.

63.2 дахь заалт. Ил санал хураалтыг дараах хэлбэрээр явуулж болно:

1. Цахим санал хураалтын систем - the computerized voting system;
2. Гар өргөх;
3. Нэр дуудах - roll-call /Гишүүдийн нэрсийг цагаан толгойн үсгийн дарааллаар дуудах бөгөөд гишүүд суудлаасаа “тийм”, “үгүй” эсхүл “санал өгөхөөс татгалзав” гэж санал өгөх эрхтэй байна/;
4. Санал хураах хуудсаар /хуулийн төсөлд гарын үсэг зурах/;
5. Цахим тоолуур ашиглан нэр дуудах-electronic roll-call /дэлгэцэн дээр гишүүдийн нэрс болон өгсөн саналыг гаргана/.

63.3 дахь заалт. Санал хураалтыг цахим тоолуур ашиглан нэр дуудаж явуулах /63.2.5/ тохиолдолд саналыг депутат тус бүрийн биометрийн үзүүлэлтийг ашиглан, эсхүл депутат тус бүрийн биометрийн үзүүлэлтийг ашиглан идэвхждэг системийг ашиглан хураана.”

Итали. Италийн Төлөөлөгчдийн танхим нь нэг гишүүн олон хүний өмнөөс санал өгч буйг таслан зогсоох зорилгоор хурууны хээгээр санал өгөх системийг 2010 онд нэвтрүүлсэн байна. Италийн Төлөөлөгчийн танхимын дэгийн 10-р бүлэгт Санал хураалтын асуудлыг тусгасан бөгөөд 49.4-5-р заалтад²³ заасны дагуу ил болон нууц санал хураалтыг цахим тоолуурын системийг ашиглан явуулж болно гэж заасан байна. /Зураг 3/

Шри Ланк. Шри Ланк Улсын хувьд 2016 оны 11-р сараас Парламентын хуралдааны санал хураалтад хурууны хээгээр санал өгөх системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн. Парламентын дэгийн хувьд одоогоор хурууны хээгээр буюу биометрийн мэдээлэл ашиглан санал өгөх зохицуулалт тусгагдаагүй байна.²⁴

Зураг 2. Болгарын Үндэсний Ассамблейн санал хураалтын систем




²³ http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf

²⁴ <https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>



Эх сурвалж: <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>

Зураг 3. Италийн Төлөөлөгчдийн танхимын санал хураалтын төхөөрөмж







Эх сурвалж: Eurel Informatica, <http://english.eurel.it/20?platform=9>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- http://computerworld.bg/inenglish/articles/34695_it_green_technologies_healthrelated_hightech_products_and_services_are_key_areas_for_bulgaria
- http://en.camera.it/application/xmanager/projects/camera_eng/file/RULES_OF_PROCEDURE_CHAMBER_OF_DEPUTIES.pdf
- http://korea.na.go.kr/res/low_02_read.jsp?boardid=1000000036
- <http://www.independent.co.uk/news/uk/politics/electronic-voting-in-for-mps-in-parliament-could-improve-accuracy-of-how-votes-are-recorded-a6875766.html>
- <http://www.ipu.org/pdf/publications/epar16-en.pdf>
- http://www.legco.gov.hk/general/english/library/stay_informed_parliamentary_news/electronic_recording_of_divisions.pdf
- http://www.nomos-leattualitaneldiritto.it/wp-content/uploads/2015/10/RoPs_Albanian-Assembly_English.pdf
- http://www.npc.gov.cn/englishnpc/Law/2007-12/12/content_1383914.htm
- http://www.npc.gov.cn/englishnpc/Law/2007-12/12/content_1383928.htm
- <http://www.parliament.bg/en/rulesoftheorganisations>
- http://www.parliament.go.ug/images/stories/constitution/rules_2012.pdf
- <http://www.sangiin.go.jp/eng/law/diet/#ChapterXV>
- http://www.shugiin.go.jp/internet/itdb_annai.nsf/html/statics/shiryo/dl-rules.htm
- <https://www.mzv.sk/documents/10182/13850/Kontrax.pdf/5e54dab8-097c-4a50-a341-e0f3ee4edd26>
- <https://www.parliament.lk/en/how-parliament-works/standing-orders>